

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/047/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 437
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭНБАЯН-
УЛААН ТОСГОНЫ ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ХҮҮХНЭЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэнбаян-Улаан тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд улсын төсвөөс 210,725.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 20,035.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 215,479.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 165.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвийн харилцах дансанд 27,107.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 419,403.2 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 70,226.7 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 816.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 348,360.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллага 2025 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 15 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ тусгаж, 82 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>96,321,725.85</u>	<u>47,444,787.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	73,436,810.45	27,107,232.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	73,436,810.45	27,107,232.39
3121	Төгрөг	73,436,810.45	27,107,232.39
31211	Төрийн сангийн харилцах	73,436,810.45	27,107,232.39
35	БАРАА МАТЕРИАЛ	22,884,915.40	20,337,555.40
351	Түүхий эд материал	895,000.00	895,000.00
35110	Тусгай зориулалттай материал	895,000.00	895,000.00
354	Хангамжийн материал	21,989,915.40	19,442,555.40
35410	Бичиг хэргийн материал	555,700.00	655,700.00
35420	Аж ахуйн материал	14,545,160.00	12,797,800.00
35440	Түлц, шатах тослох материал	900,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	5,989,055.40	5,989,055.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>121,617,414.20</u>	<u>121,168,669.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	121,617,414.20	121,168,669.10
392	Биет хөрөнгө	118,349,414.20	117,900,669.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	132,926,198.00	132,926,198.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,143,773.68)	(29,923,173.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,517,975.00	13,116,975.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,141,497.47)	(6,706,225.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,229,978.50	7,259,978.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,867,804.19)	(2,465,020.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,152,000.00	10,152,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,544,766.82)	(7,681,166.85)
39217	Ном	1,221,104.86	1,221,104.86
393	Биет бус хөрөнгө	3,268,000.00	3,268,000.00
39301	Програм хангамж	780,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(780,000.00)	(780,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,268,000.00	3,268,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>217,939,140.05</u>	<u>168,613,456.89</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>217,939,140.05</u>	<u>168,613,456.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	217,939,140.05	168,613,456.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,654,023.00	9,654,023.00
51101	Өмч: - төрийн	9,654,023.00	9,654,023.00
512	Хуримтлагдсан үр дүн	189,880,262.95	140,554,579.79
51210	Өмнөх үеийн үр дүн	189,880,262.95	189,880,262.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	(49,325,683.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,404,854.10	18,404,854.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>217,939,140.05</u>	<u>168,613,456.89</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	196,549,100.00	178,943,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,629,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,629,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	9,629,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	9,629,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,549,100.00	169,314,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	184,887,700.00	149,279,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,887,700.00	149,279,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,661,400.00	20,035,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,661,400.00	20,035,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	171,778,794.21	228,269,583.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171,778,794.21	228,269,583.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,168,757.85	228,104,565.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,530,725.05	151,417,166.54
210101	Үндсэн цалин	86,795,284.05	128,720,795.54
210102	Нэмэгдэл	30,735,441.00	21,418,534.00
210104	Урамшуулал	-	1,277,837.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,415,886.38	17,089,611.52
210201	Тэтгэврийн даатгал	9,950,790.51	11,793,719.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,140,914.03	1,318,168.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	821,640.44	871,468.44
210204	Ажилгүйдлийн даатгал	590,144.92	831,081.68
210205	Эрүүл мэндийн даатгал	1,912,396.48	2,275,173.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,501,363.64	20,770,682.15
210301	Гэрэл, цахилгаан	1,766,363.64	4,199,982.15
210302	Түлш, халаалт	6,735,000.00	16,145,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	425,700.00
2105	Нормативт зардал	10,466,700.00	18,987,000.00
210502	Хоол, хүнс	10,466,700.00	18,987,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,000.00	1,225,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	110,000.00	1,225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,144,082.78	18,615,105.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,133,750.00	7,122,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	595,500.00	1,414,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,414,832.78	10,077,745.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,610,036.36	165,017.85
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,610,036.36	165,017.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,610,036.36	165,017.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24,770,305.79	(49,325,683.16)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	24,770,305.79	(49,325,683.16)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>196,549,100.00</u>	<u>169,314,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,549,100.00	169,314,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	184,887,700.00	149,279,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,887,700.00	149,279,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,661,400.00	20,035,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,661,400.00	20,035,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>161,964,511.43</u>	<u>215,644,478.06</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	161,964,511.43	215,644,478.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,354,475.07	215,479,460.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,716,796.05	151,407,166.54
210101	Үндсэн цалин	86,252,416.00	98,227,534.00
210102	Нэмэгдэл	24,498,542.05	49,518,965.54
210104	Урамшуулал	5,965,838.00	3,660,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,229,815.38	17,089,611.52
210201	Тэтгэврийн даатгал	10,764,719.51	11,793,719.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,140,914.03	1,318,168.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	821,640.44	757,153.06
210204	Ажилгүйдлийн даатгал	590,144.92	738,397.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,912,396.48	2,482,173.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,051,363.64	19,870,682.15
210301	Гэрэл, цахилгаан	1,766,363.64	4,199,982.15
210302	Түлш, халаалт	6,285,000.00	15,245,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	425,700.00
2105	Нормативт зардал	10,222,200.00	18,987,000.00
210502	Хоол, хүнс	10,222,200.00	18,987,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	-
210604	Урсгал засвар	2,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	705,000.00	1,225,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	705,000.00	1,225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,429,300.00	6,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,543,300.00	4,803,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,886,000.00	2,096,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,610,036.36	165,017.85
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,610,036.36	165,017.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,610,036.36	165,017.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>34,584,588.57</u>	<u>(46,329,578.06)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,584,588.57	(46,329,578.06)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		73,436,810.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	73,436,810.45	27,107,232.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	189,880,262.95	-	217,939,140.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	189,880,262.95	-	217,939,140.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	189,880,262.95	-	217,939,140.05
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	189,880,262.95	-	217,939,140.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(49,325,683.16)		(49,325,683.16)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	140,554,579.79	-	168,613,456.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	230,761,100.00	215,479,460.21	15,281,639.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,761,100.00	215,479,460.21	15,281,639.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,761,100.00	215,479,460.21	15,281,639.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,974,200.00	151,407,166.54	10,567,033.46
210101	Үндсэн цалин	105,310,900.00	98,227,534.00	3,415,163.46
210102	Нэмэгдэл	53,888,000.00	49,518,965.54	8,037,237.00
210104	Урамшуулал	2,775,300.00	3,660,667.00	(885,367.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,119,500.00	17,089,611.52	3,029,888.48
210201	Тэтгэврийн даатгал	13,640,700.00	11,793,719.22	1,846,980.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,619,800.00	1,318,168.21	301,631.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	809,800.00	757,153.06	52,646.94
210204	Ажилгүйдлийн даатгал	809,800.00	738,397.06	71,402.94
210205	Эрүүл мэндийн даатгал	3,239,400.00	2,482,173.97	757,226.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,035,700.00	19,870,682.15	165,017.85
210301	Гэрэл, цахилгаан	4,360,000.00	4,199,982.15	160,017.85
210302	Түлш, халаалт	15,250,000.00	15,245,000.00	5,000.00
210303	Цэвэр, бохир ус	425,700.00	425,700.00	-
2105	Нормативт зардал	20,067,300.00	18,987,000.00	1,080,300.00
210502	Хоол, хүнс	20,067,300.00	18,987,000.00	1,080,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		-	-
210604	Урсгал засвар		-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,225,100.00	1,225,000.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,225,100.00	1,225,000.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,339,300.00	6,900,000.00	439,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,243,100.00	4,803,800.00	439,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,096,200.00	2,096,200.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	230,761,100.00	169,149,882.15	61,611,217.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	210,725,400.00	149,279,200.00	61,446,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	210,725,400.00	149,279,200.00	61,446,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,035,700.00	19,870,682.15	165,017.85
132001	Орон нутгийн төсвөөс	20,035,700.00	19,870,682.15	165,017.85
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		73,436,810.45	(73,436,810.45)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,107,232.39	(27,107,232.39)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар явцад 70,226.7 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлан дахь Машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 144.7 мянган төгрөгөөр, Бусад үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 64.2 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн, тухайн дансдын тайлант хугацааны элэгдлийн зардлыг 406.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг нөхөн бодуулж, эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн алдааг залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 8,000.0 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 61,446.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаж, төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоо бичилт хийгээгүй байсныг тохируулсан.
- Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг 165.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг бууруулж залруулсан.

3.1 Төлбөрийн акт

- Нийгмийн даатгалын газраас тогтоосон торгуулийг цалингийн зардлаас шилжүүлэн барагдуулсан зөрчилд 250.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт
- Ээлжийн амралттай байх хугацаанд ажилтанд 566.2 мянган төгрөгийн цалин илүү тооцон олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

- Шилэн дансны цахим сайтад зайлшгүй мэдээлэх мэдээллийг орхигдуулах, хугацаа хоцроон мэдээлэх зөрчилд 348,360.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

*Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинд хамаарахгүй тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаг-даагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцсон	1	615.5			1	615.5	1	615.5				
Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн	1	69,446.2			1	69,446.2	1	69,446.2				
	1	165.0			1	165.0	1	165.0				
Дүн	3	70,226.7	0	0	3	70,226.7	3	70,226.7	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	250.0	1	250.0								
Ээлжийн амралтын цалинг илүү тооцон олгосон	1	566.2	1	566.2								
Дүн	2	816.2	2	816.2								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан	1	348,360.2			1	348,360.2		
Дүн	1	348,360.2			1	348,360.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 74 - А2371281

Чингис хот

ХЭА - 2026/047/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хугацаа хоцроон илгээснээс үүдэн тогтоосон 250,000.00 (хоёр зуун тавин мянга) төгрөгийн торгуулийг цалингийн зардлаас төлж барагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно;" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Торгуулийн 250,000.00 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг нягтлан бодогч М.Хангайгаар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг эрхлэгчийн үүргийг хавсран гүйцэтгэгч М.Хүүхнээд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 75 - А23-71281

Чингис хот

ХЭА - 2026/047/НА-СТА-ТШЗ

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 566,243.70 (таван зуун жаран зургаан мянга хоёр зуун дөчин гурван төгрөг далан мөнгө) төгрөгийн цалинг давхардуулан тооцон олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:


1. Илүү олгосон 566,243.70 (таван зуун жаран зургаан мянга хоёр зуун дөчин гурван төгрөг далан мөнгө) төгрөгийг нягтлан бодогч М.Хангайгаар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг эрхлэгчийн үүргийг хавсран гүйцэтгэгч М.Хүүхнээд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 226 - А2371281

Чингис хот

ХЭА - 2026/044/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим системд 348,360,243.68 (гурван зуун дөчин найман сая гурван зуун жаран мянга хоёр зуун дөчин гурван төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 7 дугаар зүйлийн 7.1.-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн байршуулдаггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг эрхлэгчийн үүргийг хавсран гүйцэтгэгч М.Хүүхнээ, нягтлан бодогч М.Хангай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н. Хэрлэнбаяр

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР

